

ОРОН НУТГИЙН СОНИН

НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС | 2015 ОНЫ АРВАНХОЁРДУГААР САР



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, “ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ГИЙН АЖИЛ ҮЙЛСИЙН ӨӨДРӨГ ЭХЛЭЛ

(6-р нүүрт)



ДАЛАНЗАДГАД,
ХАНБОГД
СУМАНД
ШИНЭ ЖИЛЭЭ
ТЭМДЭГЛЭВ

(3-р нүүрт)



З.УЯНГА: 2016
ОНЫ ЭХЭЭР
ӨСВӨР, ҮЕ
ЗАЛУУЧУУДАД
ЭЭЛТЭЙ КЛИНИК
НЭЭНЭ

(8-р нүүрт)



“ГАЛБЫН ГОВЬ
ЗАЛУУСЫН ДУРАНД”
ГЭРЭЛ ЗУРГИЙН
УРАЛДААНЫ ДҮН
ГАРЛАА

(12-р нүүрт)

Мэндгшлээ



Andriy Vudlay

Эндрью Вүдлэй

“Оюу толгой” ХХК-ийн
Ерөнхийлөгч бөгөөд
Гүйцэтгэх ерөнхий
захирал

Сайн байцгаана уу?

Угтан ирэх шинэ жилийн өмнөхөн Оюу толгой хэмээх өнөр өтгөн гэр бүлийнхээ өмнөөс та бүхэнтэй мэндчилж, захиа үзэглэж буйдаа туйлын баяртай байна.

Оюу толгойчуудын хувьд улиран өнгөрч буй оны хамгийн үнэ цэнтэй амжилт нь аюулгүй ажиллагааны ололт байлаа.

Манай хамт олны хэн нь ч хайртай гэр бүл, найз нөхөд, ахан дүүстээ эсэн мэнд эргэн

очих нь цаашид ч бидний амжилтын үндсэн хэмжүүр байх болно. Тиймээс би манай компанийнхан дэлхий даяарх бизнесийнхээ хэмжээнд хамгийн аюулгүй ажиллагаатай хамт олон гэдгээ батлан харуулж, тэднийг манлайлж чадсан гэдгийг бахархан дурмаар байна. Бид аюулгүй ажиллагаагаа хэвшил болгож, осол аюулаас үргэлж ангид байх ёстой. Сэтгэл түгшээсэн, осолд дөхсөн тохиолдлууд, урьдчилан сэргийлэх боломжтой бэртэл гэмтэл хэд хэдэн гарсан учраас улам хянамгай, анхаарал болгоомжтой ажиллаж, аюулгүй ажиллагаатай бизнесээ бататгах шаардлагатай юм.

Бид хэдийгээр аюулгүй ажиллагаагаа нэн тэргүүнд тавин ажилладаг ч манай биенесийн хэмжээнд томоохон амжилтууд тохиолоо. Манай бизнесийн зах зээлд тулгарч буй өнөөгийн сорилтуудыг даван гарахын тулд зардлаа бууруулж, бүтээмжээ нэмэгдүүлэн, улирал тутмын үйлдвэрлэлийнхээ төлөвлөгөөг давуулан биелүүлж, үйлдвэрлэлдээ өндөр бүтээмжтэй хэд

хэдэн шинэчлэлт хийн нийтдээ 1.5 сая тонн баяжмал тээвэрлээд байна. Энэхүү түүхэн амжилтын явцад хамтрагч орон нутагтайгаа харилцан үр ашигтай, тогтвортой, урт удаан хугацааны харилцаа холбооны үндэс суурь болсон “Хамтын ажиллагааны гэрээ” байгууллаа.

Бид энэ жил далд уурхайн үйл ажиллагааг урагшлуулах “Далд уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө”, энэ сарын эхээр олон улсын 20 гаруй зээлдүүлэгчийн тусламжтай уг төслийн санхүүжилтийн гэрээнд Монгол Улсын Засгийн газартай хамтран гарын үсэг зурлаа. Энэ бүхэн Оюу толгойн уурхайн урт хугацааны амжилтыг бататгах, бизнесийн эрхэм зорилгодоо хүрэхэд чухал ач холбогдол бүхий алхмууд юм.

Бид 2015 онд хийж бүтээсэн бүхнээрээ бахархах ёстой. Энэ бол манай ажилчид, хамтран зүтгэгчдийн нөр их хөдөлмөрийн үр шим юм. Манай нийт ажиллах хүчний 95 гаруй хувийг бүрдүүлдэг монгол ажилчид, хамтран зүтгэгч ханган нийлүүлэгчид, орон нутгийн иргэдийн эрч хүч, амлалт, анхаарал бүхэн бидний амжилтын нууц юм.

Оюу толгой бол зөвхөн бидний хувьд ч биш Монгол Улсын хувьд ирээдүйн боломжийн бэлгэ тэмдэг, илэрхийлэл бөгөөд бид ирж буй он жилүүдэд хамтран ажилласнаар энэхүү боломжийг бүрэн дүүрэн ашиглаж, амьдралдаа хэрэгжүүлнэ гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

Та бүхэнд шинэ жилийн мэнд хүргэж, угтан ирж буй 2016 ондоо аюулгүй, эрүүл энх байхыг хүсэн ерөөе.

ДАЛАНЗАДГАД, ХАНБОГД СУМАНД ШИНЭ ЖИЛЭЭ ТЭМДЭГЛЭВ

“Оюу толгой” компанийн зарим ажилтан өөрийн амьдран суудаг аймаг, сумандаа анх удаа шинэ жилээ тэмдэглэсэн юм. Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд суманд болсон шинэ жилийн баярын талаар хүмүүсийн сэтгэгдлийг сонслоо.



Д.Болдбаатар, С.Наранцэцэг:

Бид хоёр 2012 оноос “Оюу толгой” компанид ажиллаж байна. Энэ оны шинэ жил Ханбогд сумын төвд болсон нь их өвөрмөц байлаа. Шинэ жилийн цэнгүүндээ оролцохын тулд 40 км явж чирэгдэл удахгүй, гэртээ ойрхон байсан нь нэг давуу тал юм. Шинэ жилийн уур амьсгал, зохион байгуулалт, хоолны амт чанар үнэхээр сайхан байсан.

Нийт Ханбогдчууддаа, “Оюу толгой” компанийн хамт олондоо шинэ оны мэнд дэвшүүлье.



Ил уурхайн хэлтсийн Хүнд машин механизмын оператор Б.Хэнмэдэхбаяр:

Би 2005 оноос Оюу толгой төсөл дээр, 2011 оноос “Оюу толгой” компанийн үндсэн ажилтнаар ажиллаж эхэлсэн юм. Жил бүр шинэ жил болдог ч энэ жилийнх гоё болсон. Заал, зохион байгуулалт, хоолны амт сайхан байлаа. Ажлынхаа хамт олонд 2016 ондоо аз хийморьтой амжилт бүтээл дүүрэн, аюул осолгүй ажиллаарай гэж ерөөе.



Цахилгаан нарийн хэмжүүрийн засварчин Н.Ангарагжав:


Би хоёр дахь удаагаа шинэ жилээ тэмдэглэж байна. Энэ жилийн шинэ жил маш сайхан боллоо. Үзэх харах, сонсох юмтай, олон олон содон зүйлстэй, бэлэг шагналаар дүүрэн байлаа. Сэтгэл хангалуун байна. Шинэ жилийг амжилттай зохион байгуулсан Даланзадгадын оффисын хамт олондоо маш их баярлалаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ ЦЭВЭР УСНЫ ШУГАМД ХОЛБОНО

Манлай сумын Эрүүл мэндийн төвийн сантехникийг шинэчлэх, цэвэр усны нэгдсэн шугамд холбох ажлыг сумын “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр гүйцэтгэж байна. Нийт 18,7 сая төгрөгийн өртөг бүхий энэхүү ажил хийгдсэнээр эмч, эмнэлгийн ажилчдын ажлыг хөнгөвчлөх, эрүүл ахуйн таатай орчин бүрдэх зэрэг ихээхэн ач холбогдолтой юм. Уг ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Манлайн бадрах” ОНӨААТҮГ гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 гаруй хувьтай байна.



ХӨӨР БАЯСАЛ ДУРСАМЖААР ДҮҮРЭН ХҮҮХЭД НАСАА ҮДСЭН ЭХ НУТАГ МИНУ



Нүд алдам их талын дунд сүндэрлэнхэн харагдах амгалан дүрт говийн ижил нэрт хос хоёр хайрхан уулсын барааг та бид харж суна. Энэ их уулс бол их талын шаргалхан нарны илчит гэрлийн өлгий-Өмнийн их говь нутаг хүй тасарч хүмүүн заяанд золголдсон мөхөс миний хиргүй ариун гэгээн тунгалаг балчирхан бага насаа үдэж гаргасан миний нутгийн шүтээн хайрхадууд билээ л. Сүүдэр

ч үл харагдах их талын элгэнд сүүмэлзэнхэн зэрэглээтэж үзэгддэг энэхүү хайрхан бол нэр алдар нь хүртэл шүлэг найраг лугаа сонсогдох “Уулган шарын домог” түүхийг агуулсан Сүм Суваргын их хайрхан уулс мину. Таньдаа тавилан заяаныхаа гэгээн бүхнийг даатгаж сөгдөн мөргөмүү.

Сүрлэг тэргүүнт таныхаа ар өвөрт тань олонтаа нүүж буун агьт талынх нь бэлчээрт хурга хариулан наадаж өссөн атлаа өнөөг хүртэл би ийм аугаа үзэсгэлэн төгөлдөр, үлэмжийн гуа болохыг тань бишрэн шүтсэн бил үү. Аавын гэрийн босгонд унаж нэг босож нэг хөлд орсон, шулгананхан наадаж хөлд орсон нутаг мину. Миний ижийнхээ гараас нь хөтөлж сүү үнэртсэн энгэрт асаж ихийн их хайранд нь өлгөйдүүлэн хүмүүн болсон нутгийн минь онгон тахилгат их

уулсын бараа дүр нь сэтгэлд мөнхрөн зүрхэнд хоногшихын учир буй. Морин эрдэнийн зоонд цагахан инээдтэй дэрвэж монгол гэрийн бууриар тамгалан нүүж буусан, үдэлж мордсон олон олон гэгээн дурсамжууд ч чухамдаа энэ л сайхан нутгийн чулуу бүхэнтэй нь хүйн холбоотой байдаг юмсан уу.

Намар намраар ижийгээрээ үнсүүлээд аавыгаа дагаж сургуульдаа явдаг байсан намайг орой намрын цагаар нулимстай үдэн гаргаж усны шувууд зөллэх урин цагийн эхээр эргэн ирэхэд минь баясах мэт өндөлзөнхөн тосдог эх нутаг минь энэ л их уулсын архан талд цэнхэртэн дуниартах цэлгэрхэн хөндийд л буй. Дэндүү жаргалтай дэврүүн гэнэхэн хүүхэд насандаа тэр



ГАЛБЫН ГОВИЙН УЛААН ТЭМЭЭ ҮҮЛДЭРЭЭР БАТЛАГДЛАА



Монголын 33 говийн нэг болох Ханбогд сумын нутагт байрлах Галбын говиор нэрлэгдсэн хоёр бөхт тэмээ Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар “Галбын улаан тэмээ” нэртэй биеэ даасан үүлдэрээр батлагдав.

Ханбогд сумын ЗДТГ нь Галбын говийн улаан тэмээг өсгөн үржүүлэх, удам угсааг хадгалан хамгаалах ажлыг бодлого болгон ажиллаж ирсэн бөгөөд уг тэмээний хянан магадлагаа

хийх ажлыг ХХААЯ, Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран хэрэгжүүлсэн юм.

Ханбогд суманд 1971 онд үржлийн тэмээний ферм байгуулсан түүхтэй бөгөөд эрдэмтэд, мал аж ахуйн мэргэжилтнүүд, нутгийн малчид хамтран Галбын говийн улаан омгийн тэмээг өсгөх ажлыг системтэй явуулсны үр дүнд өнөөдөр бие даасан үүлдэрийн хэмжээнд хүрчээ.

Тэмээн сүрэг үүлдрээр батлагдсан нь тухайн тэмээний үнэлэмж, ашиг шимийн үнэлгээ дээшлэх, малчид, аж ахуйн нэгжүүд тэмээн сүргийг өсгөн үржүүлэх идэвх санаачилга нэмэгдэх ач холбогдолтой юм. Нөгөө талаар тэмээн сүргийн үнэлэмж дээшилж, тэмээний гаралтай бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадвар сайжирна.

Галбын говийн бахархал болсон тэмээн сүрэг бие даасан үүлдрээр батлагдаж байгаад говийн ард түмэн баяртай байна.

Ханбогд сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга Д.Хүрэлбаатар

бүр анзааран ажиглаж байгаагүй ер бусын гуа үзэмж гэгчийг өнөөдөр л би олж харсан мэт бишрэн буйдаа ч түмэнтээ гайхнам. Байгаль ижийн урласан мөнхийн гоо үзэсгэлэн, хүй цөглөсөн эх нутгийн тухай цагаахан дурсамж хэмээгч чухамдаа алсхан холдсон он цагийн тэртээх балчирхан насандаа хурга тугалын бэлчээрт тоглож өссөн эх нутгийн эд эс бүхэнд оршин агуулагдаж байдаг ч юм болов уу даа.

Ихийн их амьдралын замаа ч таны л дэргэдээс эхлүүлж, ирж буцахын цагт ижий минь сүү өргөн үдэж гаргасны учир эргэн эргэн очиж нутгийн тахилгат их хайрхан таньдаа хүйн холбоотой байж мартаж чаддаггүйн шалтгаан үүнд л байнам. Зүүд нойрон дундаас ч найрсанхан наашлах Сүм Суваргын их уулс бол их Монголын алдар суут гучин гурван говийн нэгэн болох Галбын говийн чимэг болсон тэмээ хэмээх тэнгэрлэг амьтны тааваар жаргах өлгий билээ. Мөхөсхөн бичээч миний хөл хөөр хөгжөөн баясалтай хүүхэд насаа үдсэн тэрхүү ээл итгээлт төрсөн нутаг-Гурван Гучингийн гол хэмээх ашид мөнхийн билэг ерөөл оршоосон амар жаргалангийн өлгий нутагтай хараа бараандаа жаргасан их хайрхан Сүм Суваргын уулс таньдаа би хайртай байхгүй ч яахсан билээ. Сүслэн залбирч сүүгээ өргөдөг, сунаж мөргөн тавилангаа даатгадаг нутгийн минь уулс, тахилга шүтээнт Сүм Суварга хэмээх бурханлиг нэрт говийн номхон бор хайрхануудаа би хүй цөглөсөн нутаг хэмээн бодож явнам.

Б.Хүрэлээ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ГИЙН АЖИЛ ҮЙЛСИЙН ӨӨДРӨГ ЭХЛЭЛ

Улиран одож буй 2015 он “Оюу толгой” компанийн хувьд үйлдвэрлэл, борлуулалт, хөрөнгө оруулалтын болон гадаад харилцаа хамтын ажиллагааны түүхэнд тодоор бичигдэх жил байлаа. Компанийн зүгээс “Оюу толгой”-н уурхайн үйл ажиллагаа явуулж буй орон нутаг болох Өмнөговь аймаг, Ханбогд сум болон бусад түншлэгч сумуудтайгаа харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжихэд ихээхэн анхаарч ирсэн. Энэ уламжлалт харилцаа хамтын ажиллагаагаа ирээдүйд чиглэсэн тогтвортой нэгдсэн нэг голдиролд оруулсан томоохон алхам энэ онд хийгдсэн нь “Оюу толгой” компани нь Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд сумтай “Хамтын ажиллагааны гэрээ”-г 2015 оны 4 дүгээр сарын 22-нд байгуулсан явдал байлаа.

Энэхүү гэрээгээр “Оюу толгой” ХХК орон нутгийн байгаль орчин, ус, уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежментийг сайжруулах, үндэсний түүх, соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрээс бараа үйлчилгээ худалдан авах зэрэг үндсэн

чиглэлүүдээр дэмжлэг үзүүлэх, аймаг орон нутгийн зүгээс Оюу толгой төсөл, “Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаар тохирон, талууд хамтын ажиллагаандаа баримтлах зарчим, нөхцөлийг тодорхойлсон юм.

Гэрээний дагуу талууд орон нутгийн хөгжлийг дэмжих сан байгуулах, уг санд “Оюу толгой” ХХК жил бүр 5.0 сая ам.долларын санхүүгийн дэмжлэг олгох, уг санхүүжилтаар дээр дурдсан нийгэм эдийн засгийн салбаруудад орон нутгийн хөгжил, хүн ардын сайн сайханд чиглэсэн нийгмийн дэд бүтцийн төсөл болон тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх юм.

Гэрээний дагуу “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-г байгуулан Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн 2015 оны 9 дүгээр сарын 25-наас албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Сангийн Харилцааны хорооны санал зөвлөмж, Удирдах зөвлөлийн шийдвэрээр 2015 онд тус санд олгогдсон санхүүжилт болох 2.0 сая ам.доллараар Даланзадгад сумын 25, 26 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг санхүүжүүлэх гэрээ байгуулан

ажиллалаа. Одоогийн байдлаар цэцэрлэгийн барилгуудын нийт санхүүжилтийн 75 хувийг олгож, барилга угсралтын ажил 80 гаруй хувьтай явагдаж байна.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлөөс говь нутгийн хүүхэд, багачууд тэр тусмаа цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа Даланзадгад сумын гэр хорооллын хэдэн зуун хүүхдэд эрүүл, аюулгүй орчинд сурч хүмүүжих бололцоо олгосон шийдвэр гаргасан нь нүдээ олсон шийдвэр боллоо. Хүүхэд, багачууд цэцэрлэгт хамрагдахаас гадна тэднийг гэрээр асарч ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа ээж, аавууд нь ажил хөдөлмөр эрхлэх бололцоотой болох юм. Түүнчлэн энэхүү төслүүдийг барилгын салбар үндсэндээ зогсонги байгаа үед орон нутгийн компани гүйцэтгэж, цөөнгүй иргэдийг ажлын байраар хангах, орон нутгаас барилгын материал, түүхий эд худалдан авах зэргээр орон нутагт тодорхой хэмжээгээр орлого нэмэгдүүлж байна.

Аймаг, орон нутгийн зүгээс ч төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүх талын туслалцаа үзүүлж, цэцэрлэгийн барилгын газар, техникийн нөхцөлийг шийдвэрлэх, барилгыг ашиглалтад хүлээн авсан дараа ажиллах багшлах боловсон хүчнийг бэлтгэх зэргээр хамтран ажилласан нь Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн гараа амжилттай байгаагийн тод илрэл юм.



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр баригдаж буй Даланзадгад сумын 26 дугаар цэцэрлэг, Гүйцэтгэгч Жи-Жи-Ай ХХК



“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн санхүүжилтээр баригдаж буй Даланзадгад сумын 25 дугаар цэцэрлэг, Гүйцэтгэгч: Хүннүгийн говь ХХК

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК БОЛОН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ КОМПАНИУДЫН МОНГОЛ АЖИЛЛАГСДЫН МЭДЭЭЛЭЛ

/2015 оны 11-р сарын 30-ны байдлаар/

| Компаний нэр | Өмнөговь аймгийн харьяат ажиллагсдын тоо | Бусад | Нийт |
|-------------------------------|--|----------------------|---------------------|
| 1 "Оюу толгой" ХХК | 376 15.7% | 2014 84.3% | 2390 100% |
| 2 Туслан гүйцэтгэгч компаниуд | 824 27.2% | 2205 72.8% | 3029 100% |
| Нийт дүн | 1200 22.1% | 4219 77.9% | 5419 100% |

| № | Харьяалал | "Оюу толгой" ХХК | Туслан гүйцэтгэгч компаниуд | Нийт |
|----|----------------------|------------------|-----------------------------|-------------|
| 1 | Өмнөговь/Баяндалай | 5 | 4 | 9 |
| 2 | Өмнөговь/Баян-Овоо | 4 | 9 | 13 |
| 3 | Өмнөговь/Булган | 2 | 0 | 2 |
| 4 | Өмнөговь/Даланзадгад | 132 | 260 | 392 |
| 5 | Өмнөговь/Гурвантэс | 1 | 0 | 1 |
| 6 | Өмнөговь/Ханбогд | 210 | 457 | 667 |
| 7 | Өмнөговь/Ханхонгор | 0 | 9 | 9 |
| 8 | Өмнөговь/Хурмэн | 2 | 1 | 3 |
| 9 | Өмнөговь/Мандал-Овоо | 1 | 2 | 3 |
| 10 | Өмнөговь/Манлай | 9 | 62 | 71 |
| 11 | Өмнөговь/Номгон | 2 | 3 | 5 |
| 12 | Өмнөговь/Ноён | 3 | 1 | 4 |
| 13 | Өмнөговь/Сэврэй | 3 | 1 | 4 |
| 14 | Өмнөговь/Цогт-Овоо | 0 | 1 | 1 |
| 15 | Өмнөговь/Цогтцэций | 2 | 14 | 16 |
| | Нийт | 376 | 824 | 1200 |

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаас Өмнөговь аймаг тэр дундаа “Оюу толгой” компанийн түншлэгч сумуудын байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам болон холбогдох мэдээллийг хүргэж иргэд, байгууллага, сумын засаг захиргаад санд хандаж төсөл бичих аргачлал зөвлөмжөөр хангах юм.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-тай холбогдох:
Цахим шуудан: batkhuyag.b@goviinoymn
sugaraab@goviinoymn

Утас: 7053-3578, 7053-3577

Хаяг: Даланзадгад сум 3 дугаар баг, Голомт бизнес төвийн 4 давхар.

З.УЯНГА: 2016 ОНЫ ЭХЭЭР ӨСВӨР, ҮЕ ЗАЛУУЧУУДАД ЭЭЛТЭЙ КЛИНИК НЭЭНЭ



НҮБ-ын Хүн амын сангийн Залуучуудын хөгжлийн төслийн менежер З.Уянгатай Ханбогд суманд байгуулагдсан “Залуучуудын хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааны талаар ярилцлаа.

“Залуучуудын хөгжлийн төв” ямар зорилготой байгуулагдсан бэ?

НҮБ-ын Хүн амын сан, “Оюу толгой” компани хамтран Ханбогд суманд өнгөрсөн 7 дугаар сард “Залуучуудын хөгжлийн төв” нээсэн. Энэ төв залуучуудад сонирхолтой, ээлтэй, аюулгүй

орчин бүрдүүлж, амьдрах ухааны чадвар эзэмшүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгож, хөдөлмөр эрхлэхэд нь хэрэгтэй ур чадварыг хөгжүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэнд, харилцаа, сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгч, өөрсдийн эрх ашигт хамаатай шийдвэрт оролцох боломжоор хангах зорилготой.

Төв байгуулагдсанаас хойш ямар үйл ажиллагаа явуулж байна вэ? Залуучуудын оролцоо, идэвх сонирхол хэр байгаа вэ?

“Залуучуудын хөгжлийн төв” зохицуулагч, нийгмийн ажилтан гэсэн үндсэн хоёр ажилтантай. Мөн дэргэдээ 15 хүний бүрэлдэхүүнтэй Залуучуудын зөвлөлтэй. Үүнд төрөл бүрийн нийгмийн бүлгийн, ажил, мэргэжлийн залуучуудын төлөөлөл багтаад төвийнхөө үйл ажиллагааны талаар шийдвэр гаргадаг. Мэдээж орон нутгийн залуучуудын хүсэл сонирхолд үйл ажиллагаа нь үндэслэнэ. Өнгөрсөн зургаан сарын хугацаанд “Залуучуудын хөгжлийн төв”-өөр давхардсан тоогоор 2790 залуу үйлчлүүлсэн тоо бий. Дэмжих бүлэг, сонирхлын клубууд байгуулагдаж байна. Бид эхний ээлжинд үе тэнгийн 25 сургагч багш бэлтгэсэн. Үүний дараа дахин

75 үе тэнгийн сургагч бэлтгээд байна. Эдгээр үе тэнгийн сургагч бүр 10 хүнд хүрлээ гэхэд сум даяар 1000 залуу хүнд хүрэх боломжтой. Төвөөс замын хөдөлгөөний дүрмийн, залуу хосуудад зориулсан сургалт, кино хэлэлцүүлэг, гэрэл зургийн уралдаан гээд төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байна. Хамгийн сүүлд залуу ээж нарын дэмжих бүлгийнхэнд дээл оёх сургалт явуулсан байна. Тэд тодорхой хэмжээнд чадвартай болж, орлого олох боломж бүрдсэн. Үүнээс гадна баг хамт олон болж, сэтгэлээ уудлан асуудлаа ярьдаг, бие биенийгээ сонсдог, шинэ санаа гарган хамтран хэрэгжүүлдэг болж байна. Энэ бүхэн бол хэлбэр. Үүгээр дамжуулж, асуудлаа шийдвэрлэх алхам хийж байгаа нь илүү чухал. Хамгийн гол нь нэг удаагийн үйл ажиллагаа яваад дуусах биш тогтмол, үе шаттай ажлууд хийж, тодорхой үр дүнд хүргэх зорилготой. Тухайлбал, өрхийн санхүүгээ хэрхэн зохицуулах тухай сургалт явууллаа гэхэд долоо хоног, сард цувралаар, тухай бүрдээ шинэ мэдээлэл өгөх, түүнийг нь бататгах байдлаар явагдана. Гэхдээ зөвхөн мэдээлэл авах биш мэдээллээ мэдлэг, мэдлэгээ чадвар, чадвараа дадал болгох хүртэл явуулах ёстой.

Танай интернэт төвөөр залуучууд хэр их үйлчлүүлдэг вэ?

Их үйлчлүүлнэ. Нээлттэй, чөлөөтэй орчин бүрдүүлсэн учраас залуучууд янз бүрийн сонирхлын журмаар олноороо ирдэг. Хүүхдүүд ч олон байсан. Үүний дараа бид илүү зорилтот бүлэг рүүгээ хандуулж, интернэтийн зөв



хэрэглээ рүү чиглүүлж эхэлсэн байгаа.

Ирэх 2016 онд ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ?

2016 онд амьдрах ухааны 12 чадвар эзэмшүүлэх сургалтууд явуулна. Залуучууд өөрсдөө хамгийн хэрэгтэй чадвараа сонгоод хамрагдах боломжтой. Дэмжих бүлэг, сонирхлын клубууд нэмэгдэх байх. Мөн сар бүр боловсрол, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй орчин гэх мэтээр сэдэвчлэн ярилцах оролцооны үйл ажиллагааг тогтмолжуулна. Үүнээс гадна бид 2016 оны эхээр өсвөр үе залуучуудад ээлтэй клиник нээхээр төлөвлөж байна.

Энэ клиник ямар үйл ажиллагаа явуулах вэ. Хичнээн хүн ажиллах вэ?

Эмнэлгүүд өсвөр үе, залуучуудад насны болон сэтгэл санааны онцлогт тохирсон эрүүл мэндийн ээлтэй үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байгаа. Тиймээс ийм клиник байгуулж, тэдний эрхийг хүндэтгэсэн, нууцыг

хадгалсан, ээлтэй, таатай орчин бүрдүүлсэнээр, залуучууд өөртөө тохиолдсон эрүүл мэнд, сэтгэл зүйн асуудлаа шийдвэрлэх боломж бий болох юм. Залуучуудын хөгжлийн төвийн хувьд залуучуудыг клиникийн үйлчилгээнд холбох үйлчилгээ үзүүлнэ. Бүх үйлчилгээ үнэ төлбөргүй.

Залуучуудын хөгжлийн төв дээр байрлах уу?

Ханбогд сум дахь Сум дундын эмнэлэг дээр байрлаж, их эмч, зөвлөхтэй ажиллана. НҮБ-ын Хүн амын сангаас эмнэлгийн тоног төхөөрөмж, оффисийн тавилга болон тохижилтын бусад зүйлийг санхүүжүүлсэн. Үзлэгийн өрөө, зөвлөгөө өгөх өрөө, сургалтын танхимтай байна. Төслийн хүрээнд байгуулсан найм дахь клиник болж байгаа.

Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс ямар оролцоо, дэмжлэгтэй байгаа вэ?

Төсөл дэмжих 9 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулсан. Сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан, сумын Иргэдийн нийтийн хурлын төлөөлөл, хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, сургуулийн захирал, цагдаагийн ажилтан, соёлын төвийн эрхлэгч, сум дундын эмнэлгийн ерөнхий эмч, Залуучуудын хөгжлийн төвийн зохицуулагч, төрийн бус байгууллага, “Оюу толгой” компанийн төлөөлөл багтсан. Энэ баг төсөл амжилттай хэрэгжихэд дэмжлэг үзүүлэх юм. Аймгийн төвшинд ч төсөл дэмжих баг бий.

Ярилцлага өгсөн танд баярлалаа.

“ДУЛААН ХУВЦАС- ДУЛААН СЭТГЭЛ” АЯНД ОРОЛЦОВ



“Оюу толгой” компанийн ажилчдын санаачилгаар бүтэн болон хагас өнчин хүүхдүүдэд хувцас хандивлах аян өрнүүлж байгаа юм. Аяны хүрээнд “Оюу толгой” компанийн Нийгмийн харилцааны хэлтсийн хамт олон “Дулаан хувцас-Дулаан сэтгэл” санаачилгыг дэмжиж, Ханбогд сумын эмзэг бүлгийн өнчин, хагас өнчин найман хүүхдэд дулаан хувцас бэлэглэн, хамтдаа зоог барилаа.



Ц.МЯГМАР-ОЧИР: ХОРШООД ТЭЖЭЭЛИЙН ЭРГЭЛТИЙН САНТАЙ БОЛЖ БАЙНА

Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвийн гүйцэтгэх захирал Ц.Мягмар-Очиртой ярилцлаа.



Танай байгууллага “Оюу толгой” компанитай хэдэн оноос, ямар чиглэлээр хамтран ажиллаж байна вэ?

Бид 2013 оноос Ханбогд, Манлай, Баян-Овоо суманд хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж ирлээ.

Оюу толгой компанитай хамтран Өмнөговь аймгийн сумуудад 2015 онд ямар ажлууд хийж гүйцэтгэсэн бэ. Ямар үр дүн гарав?

Эдгээр сумуудын хоршоодын хөгжлийг үнэлэх, үнэлгээгээр тодорхойлогдсон хэрэгцээнд нь тохирсон зөвлөгөө өгөх, “Оюу толгой” компаниас зарлаж байгаа сонгон шалгаруулалтад хоршоодыг оролцоход нь зөвлөх зэргээр тэднийг бие даан хөгжих боломжийг илүү анхаарч ирлээ. Ханбогд сумын “Төрлийн мянган тайж”, “Их ногоон гурвалжин”, “Баян саглар” хоршоо малын эрүүл мэндийг сайжруулах төслийн сонгон шалгаруулалтад шалгарч дэмжлэг авсан. Ингэснээр гишүүдийн мал сүргийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмжтэй болсноос гадна хамтран ажиллах туршлага олж авлаа. Мөн “Галба дайчин” хоршоо Ханбогд сумын нутагт 7.5 га газарт заган ойг нөхөн сэргээх ажил эхлүүлээд байна. Үүнээс гадна Өмнөговь аймгийн “Малчдын зөвлөгөөн-2015” арга хэмжээг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, тус аймагт үйл ажиллагаа явуулдаг бүх хоршоодын дарга, санхүүгийн ажилтан нарт зориулсан сургалт, семинар хийлээ. Мөн Ханбогд сумын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөр /2016-2025/ боловсрууллаа. Чиглэгдсэн гурван сумын хоршоо тус бүрт

2.0-5.0 сая төгрөгийн тэжээлийн эргэлтийн сангийн хөрөнгө бий болсон байгаа. Үйл ажиллагаа нь харьцангуй жигдэрч байгаа хоршоодод төлөвлөсөн бизнесээ хийхэд нь зориулж, “Оюу толгой” компаниас уралдаан зарлаж эхний гурван байрт орсон хоршоодод нийтдээ 20 сая төгрөгийн урамшуулал олгохоор шийдсэн. Хоршоодыг хуулийн наад захын шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар гурван удаагийн үнэлгээ хийж шаардлагатай зөвлөгөө өглөө.

Хоршоо байгуулах, зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах чиглэлээр ямар ажлууд хийсэн бэ?

Өнөөдрийн байдлаар гурван суманд 18 хоршоо байгуулагдан ажиллаж байна. Тухайн сумуудын зах зээл, хүн амтай харьцуулбал хангалттай олон хоршоо. Мэдээж амьдрал баян учраас тодорхой шалгуур хангасан, гишүүдийн итгэлийг хүлээсэн хоршоод амжилтад хүрнэ. Өөрөөр хэлбэл олон хүчин зүйлээс шалтгаалан байгуулагдсан хоршоод ирэх он жилүүдэд тооноос чанар луу шилжих шаардлага гарна. Бид энэ талаас нь бодож сургалт зөвлөгөө өгч ирсэн. Тухайлбал цөөн гишүүнтэй олон жижиг хоршоодоос олон гишүүнтэй нэг томоохон хоршооны амьдрах чадвар, хөгжих боломж илүү хурдан, сайн байдаг талаар Говь-Алтай аймгийн Дарив сумын Улсын тэргүүний “Буян-Ундрал” хоршооны дарга, Монгол улсын гавьяат эдийн засагч Б.Авирмэдээр лекц уншуулсан.

Энэ лекцийн үр дүнгийн талаар тодруулж

Болох уу?

Их үр дүнтэй ажил болсон. Үр дүнтэй гэдгийн учир нь одоо зарим хоршоод Б.Авирмэд даргаар сумын бүх иргэдэд лекц уншуулж, зах зээлд өрсөлдөх чадвартай олон гишүүд бүхий хоршоог хамтран байгуулахад иргэд, малчдыг идэвхжүүлэх талаар санал гаргаж байгаа. Б.Авирмэд дарга 200 гаруй өрхийн 400 гишүүнтэй, жилдээ нэг тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийдэг томоохон хоршоог хөгжүүлэхэд ердөө хэдхэн зарчим л баримталсан талаар танилцуулсан. Тухайлбал, нэгдүгээрт, Гишүүн өрх бүр хоршооныхоо өмнө тодорхой үүрэг хүлээдэг байх, хоёрдугаарт, Хоршоо үнийн зөрүүг шударгаар хувиарладаг байх, гуравдугаарт, Хувь хөрөнгийн хэмжээнд нь хувь тэнцүүлэн ногдол орлого хувиарладаг байх, дөрөвдүгээрт, Гишүүдийн хувь хөрөнгийн өсөлтийг хөхиүлэн дэмжих, тавдугаарт, Гишүүдийг хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн бодлогоор байнга дэмжих гэсэн дээрх 5 зарчим нь шинэ тутам байгуулагдсан хоршоодыг хөгжихөд ихээхэн тус болдог нь улсын тэргүүний Буян-Ундрал хоршооны туршлагаар нотлогдсон учир хоршоод үйл ажиллагаандаа өөрийн орон нутгийн болон хоршооны онцлогт тохируулаад дээрх зарчмуудыг хэрэглэх нь зүйтэй юм. Эдгээр зарчмыг манай хоршоод анхаарч ажил хэрэг болгох бүрэн боломжтой.

2015 онд хоршоодыг туршлага судлуулах чиглэлээр ямар ажлууд хийсэн бэ?

Бусад аймаг, сумдын ижил төрлийн хоршоодын үйл ажиллагаатай танилцах, харилцан туршлага солилцох, малын ноос, ноолуураар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үндэсний үйлдвэрүүдийг үзэх, үйлдвэрүүдийн удирдлагатай уулзаж малын түүхий эд нийлүүлэх хамтын ажиллагааг эхлүүлэх гол зорилготой хоёр удаагийн аяллаар нийтдээ 42 төлөөлөгч, 6 аймгийн 18 хоршоо, 5 үндэсний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсан. Хоршоод бизнесийн шинэ санаанууд олж авах, үндэсний үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан ноос ноолуураа шууд худалдах, Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны орон нутгийн төлөөлөгчөөр ажиллах зэрэг олон боломжийг бий болгож чадсан.

Хоршоо амжилттай, тогтвортой ажиллах гол суурь бол санхүү. Тэгвэл хоршоодын санхүүг бэхжүүлэх чиглэлээр ямар ажлууд санаачилан гүйцэтгэсэн бэ?

Говийн бүсэд мал аж ахуй эрхлэхэд тулгардаг хамгийн том бэрхшээл нь малын тэжээл бэлтгэлийн асуудал байдаг. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд гишүүддээ дэмжлэг үзүүлэх нь хоршоодын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг гэж үзээд хоршоодын дэргэд “Малын тэжээлийн эргэлтийн сан” байгуулах санаачилга гаргасан. Түүнийг “Оюу толгой” компани болон орон нутгийн Засаг дарга нар дэмжиж ажилласан. “Оюу толгой” компани бүсийн гурван сумын хоршоодод тэжээлийн эргэлтийн санг бий болгох зорилгоор нийт 76.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 215.7 тн

малын тэжээл олгосон. Хоршоод өөрийн гишүүд болон гишүүн бус малчид, мал бүхий иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулж тэжээлийн эргэлтийн санг бүрдүүлсэн. 2015 оны 12 дугаар сарын эхний байдлаар хоршоодын эргэлтийн санд 68.4 сая төгрөгийн хөрөнгө хуримтлагдаад байна. Зарим хоршоод өөрсдийн санаачилгаар тэжээлийн эргэлтийн сангийн хөрөнгөөрөө өвс, тэжээл татаж өвлийн бэлтгэлээ хангаж байгаа нь нэн сайшаалтай. Түүнчлэн үлдсэн хоршоод нь малын өвс, тэжээл худалдан авахаар нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хэлцэл хийж эхэлсэн мэдээлэл ч байгаа. Тэжээлийн эргэлтийн сантай болсноор гишүүдийнхээ мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах, хоршоодын санхүүг бэхжүүлэхэд томоохон дэмжлэг болж байна гэж тэд үзэж байгаагаа илэрхийлсэн.

Ирэх 2016 онд хийх ажлынхаа талаар товч танилцуулж болох уу?

“Оюу толгой” компанитай байгуулсан бидний гэрээ энэ 12 сард дуусч байгаа. Гэхдээ хоршооллын хөдөлгөөнийг дэмждэг байгууллагын хувьд эдгээр хоршоодоо орхихгүй цаашид хамтран ажиллаж, шаардлагатай сургалт зөвлөгөөг зайнаас ч болов үзүүлээд явах бодол бий. Хамтын гэрээний үр дүнд эдгээр сумуудад хоршооллын хөдөлгөөний суурь тавигдсан гэж бодож байна. Цаашдын хөгжил нь тухайн хоршооны гишүүд удирдлага, орон нутгийн дэмжлэгээс ихээхэн хамаарна.



“ГАЛБЫН ГОВЬ ЗАЛУУСЫН ДУРАНД” ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНЫ ДҮН ГАРЛАА

Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчидтай хамтарсан зэрлэг амьтны ажиглалт, тооллого төслийн хүрээнд Ханбогд сумын Залуучуудын хөгжлийн төв болон “Оюу толгой” ХХК хамтран “Галбын говь залуусын дуранд” байгаль, зэрлэг амьтны сэдэвт гэрэл зургийн уралдааныг 2015 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сарын 25-ныг дуустал зарласан юм. Энэхүү уралдаанд идэвхтэй оролцож, 70 орчим гэрэл зураг ирүүлсэн оролцогчиддоо талархлаа илэрхийлье.

Оролцогчдын нэрийг нууцалсан нийт зургуудаас шилдэг 10 зургийг шалгаруулж, тэдгээрээс шилдэг 3 зургийг тодруулан уралдааны шалгуур үзүүлэлтийг баримтлан шилдэг гурван зургийг тодрууллаа. Шилдэг зургийн эзэд болсон та бүхэнд баяр хүргэе.

ТЭРГҮҮН БАЙР



Нэр: Т.Түмэнбаяр

Зураг авсан аппаратны загвар: Canon EOS 5D

Зургийн нэр: Дэмчог хийд ба
Долоон бурхан од

ДЭД БАЙР



Нэр: Д.Буянтогтох

Зураг авсан аппаратны загвар: Canon Power-
Shot SX10 IS

Зургийн нэр: Галбын уулын янгир

ГУРАВДУГААР БАЙР



Нэр: О.Батзориг

Зураг авсан аппаратны загвар: Canon EOS 60D

Зургийн нэр: Гал сүүлт

Шүүгчид

- СТА, мэргэжлийн зураач Ж.Чингэс, “Оюу толгой” ХХК
- Амьтан судлаач С.Амарсайхан, “Оюу толгой” ХХК
- Нийгмийн ажилтан Б.Энхжаргал, Ханбогд сумын “Залуучуудын хөгжлийн төв”

ХАНБОГД СУМЫН ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв

2015 оны 12 дугаар сарын 11

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтад Ханбогд сумын Захиргаа, Малчид, “Оюу толгой” ХХК-ийн төлөөллүүд болон Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нар оролцов.

Уг уулзалтаар “Оюу толгой” компанийн төлөөллийн зүгээс Бор овоогийн задгайн өөрчлөлтийн байдлын талаар мэдээлэл өгч, сумын захиргаа болон малчдын төлөөлөлд шинэ Бор овоогийн задгайн тохижуулалтыг танилцуулах аялал зохион байгуулахаар болов. Мөн Ундайн голын гольдролын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ хийсэн Хөндлөнгийн шинжээчдийн багийн 1-р шатны үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим асуудлыг хэлэлцлээ. Үүний нэг нь Ундайн голын экосистемийн үйлчлэлийн эдийн засгийн үнэлгээг хэрэгжүүлэх тухай 10-р зөвлөмж юм. Уг аргачлалын талаар Талууд хэлэлцсэний эцэст холбогдох судлаачид мэргэжилтнүүдийн саналыг тодруулсны үндсэн дээр дахин хэлэлцэхээр санал тохиров. Үүний дараа 13-р зөвлөмжийн асуудалтай холбогдуулан Ундайн гол дагуу нутагладаг малчин өрхийн санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх тухай хэлэлцсэн бөгөөд малчин өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл боловсруулахаар санал нэгдлээ.

Энэхүү хурлын өмнөх өдөр буюу 12 дугаар сарын 10-нд ЭЗХЗОГ –аас зохион байгуулсан Зөрчил маргаан шийдвэрлэх чадвар дээшлүүлэх сургалтад Зөвлөлийн гишүүд хамрагдлаа. Сургалтаар зөрчил маргаан, ашиг сонирхол, төсөөллийг ойлгох, маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл сэдвээр хичээл зааж дадлага хийсэн юм. Уг сургалтыг зохион байгуулсан ЭЗХЗОГ-ын чиглүүлэгч багш нарт Зөвлөлийн гишүүд талархал илэрхийллээ.

Гурван талт зөвлөлийн тухай


Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон “Оюу толгой” компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 дугаар сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группийн Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага.

Орон нутгаас ирүүлсэн санал, гомдол ба хүсэлт

2015 оны 11 – р сар (10 сарын 25 – 11 сарын 27) (Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сум)

Санал, гомдол: Орон нутгаас энэ сард ямар нэг санал хүлээн аваагүй, харин гэрээт компаний гүйцэтгэсэн худаг засварын ажилтай холбоотой нэг гомдол хүлээн авсны дагуу шаардлагатай арга хэмжээг авч шийдвэрлэлээ.

Хүсэлт: Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нийтдээ 24 хүсэлт хүлээн авсан ба эдгээрээс 11 хүсэлтэд холбогдох асуудлыг судлан шийдвэрлэж хариуг өгөөд байна. Хүсэлтүүдийн ихэнх хувийг дэмжлэг туслалцаа, хандив хүссэн хүсэлт буюу гэр хүссэн хүсэлт эзэлсэн байлаа. Харин үлдсэн хувийг уурхайн талбайд зочлох, хүний нөөц/нөхөн олговор, бусад буюу хамтран ажиллах тухай хүсэлтүүд байв. Хариу өгөгдөөгүй байгаа хүсэлтүүдийн дагуу зохих ажлуудыг зохион байгуулж, шийдвэрлэхээр ажиллаж байна.



Санал, гомдол, хүсэлтийг: Соёлын өв, байгаль орчин, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хангамж, хандив тусламж, хүний эрх, барилга бүтээн байгуулалт/гэрээтүүд, хүний нөөц, олон давтан гаргасан болон бусад гэсэн төрлүүдээр бүртгэдэг.

“Оюу толгой” компанитай холбоотой асуудлаар otcommunities@ot.mn хаягаар эсвэл 9903 4732 (Оюу Толгой уурхай), 9509 0391 (Ханбогд сумын оффис), 95091907 (Манлай сумын оффис), 9909 8406 (Даланзадгад сумын оффис) руу холбогдоно уу. Санал, гомдлын маягтыг дээрх оффисуудаас авч болно.


Орон нутгаас ирүүлсэн санал, гомдол ба хүсэлт

2015 оны 12 – р сар (11 сарын 28 – 12 сарын 25) (Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сум)

Санал: Орон нутгаас тайлант сарын хугацаанд дэд бүтэц, хүний нөөцтэй холбоотой хоёр эерэг санал, бусад төрөл дээр нэг төвийг сахисан санал хүлээн авсан буюу уг саналын дагуу зохих хариуг өгөөд байна.


Гомдол: Энэ сард малын осолтой холбоотой нэг гомдол хүлээн авсан ба шуурхай арга хэмжээг авч гомдлыг хаасан болно.

Хүсэлт: Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нийтдээ 9 хүсэлт хүлээн авсан ба эдгээрээс 8 хүсэлтэд холбогдох асуудлыг судлан шийдвэрлэж хариуг өгөөд байна. Хүсэлтүүдийн ихэнх хувийг дэмжлэг туслалцаа, хандив хүссэн хүсэлт эзэлсэн байлаа. Харин үлдсэн хувийг уурхайн талбайд зочлох, хүний нөөц, хангамжийн тухай хүсэлтүүд байв. Хариу өгөгдөөгүй байгаа хүсэлтийн дагуу шаардлагатай ажлуудыг зохион байгуулж байна.



Санал, гомдол, хүсэлтийг: Соёлын өв, байгаль орчин, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хангамж, хандив тусламж, хүний эрх, барилга бүтээн байгуулалт/гэрээтүүд, хүний нөөц, олон давтан гаргасан болон бусад гэсэн төрлүүдээр бүртгэдэг.

“Оюу толгой” компанитай холбоотой асуудлаар otcommunities@ot.mn хаягаар эсвэл 9903 4732 (Оюу Толгой уурхай), 9509 0391 (Ханбогд сумын оффис), 95091907 (Манлай сумын оффис), 9909 8406 (Даланзадгад сумын оффис) руу холбогдоно уу. Санал, гомдлын маягыг дээрх оффисуудаас авч болно.



© Г.Амархүү

Анхидал ангир (Tadorna tadorna)

Таних шинж:

Биеийн урт 55-65 см. Далавчны дэлхэц 100-120 см. Содон өнгөтэй шувуу. Цагаан, хар, улаан шаргал хосолсон зүстэй. Толгой, хүзүү хар ногоон, хушуу улаан, хөл ягаан.

Статус ба нүүдэл:

Өндөглөн зусдаг, нүүдлийн, ердийн тохиолдох зүйл. Хавар 3-р сарын сүүл, 4-р сарын эхээр нүүдэллэн ирж 8-р сарын сүүлээс 9-р сарын сүүл хооронд буцна.

Амьдрах орчин:

Ухсан нүх, хад, бутны дор зэрэг газар үүрлэж, өндөглөнө. Өндөгнөөс дэгдээхэй гарснаас хойш удалгүй ойролцоох устай газарт очиж амьдарна. Ханбогд сумын нутгаар нүүдлийн үедээ жижиг нуур, цөөрмүүдээр тохиолдоно.

Идэш тэжээл:

Нуур, чийгтэй нуга, намгийн усны болон хуурай газрын ногоон ургамлаар хооллоно. Үржлийн үедээ шавж, өт хорхой, загас, мэлхийгээр хооллоно.

Зэрлэг нугас (Anas platyrhynchos)

Таних шинж:

Биеийн урт 50-60 см, далавчны дэлхэц 81-95 см урт. Эр нь ногоон толгойтой, хушуу шар өнгөтэй. Толгой, цээж хоёрыг заагласан цагаан хүзүүвчтэй. Эм нь эрэн цайвар хүрэн зүстэй. Зулай болон нүд дагасан бараан судалтай. Сүүл цагаан эмжээртэй. Хөл улаан шаргал.

Статус ба нүүдэл:

Өндөглөн зусдаг, нүүдлийн, ердийн тохиолдох шувуу. Хавар 4-р сарын эхээр ирж,


8-р сарын сүүлээс 10-р сарын эх хооронд буцна. Зарим нь нуур, голын хөлдөөгүй хэсэгт өвөлжинө.

Амьдрах орчин:

Гол мөрөн, нуурын зэгс, өндөр ургамалтай, шигүү буттай газар үүрлэнэ. Ханбогд сумын нутгаар нүүдлийн үедээ жижиг нуур, цөөрмүүдээр тохиолдоно.

Идэш тэжээл:

Шавж, өт хорхой, ургамлын үр, үндэс иднэ. Нүүдлийн үедээ тариан талбайд цуглаж буудайн үрээр хооллоно.



Редактор Ч.Батпүрэв

Мэдээллийг бэлтгэсэн: Б.Танхилдулам, Н.Мөнхбаяр, С.Эрдэнэбат, Ж.Мөнгөндолоо, Л.Ариунчимэг, П.Золбуянхишиг

Гэрэл зургийг: А.Хатан-Оол, Ц.Мөнхчулуун

Зохион байгуулагч: Н.Сосорбурам

Хэвлэлийн эхийг: Г.Мандах-Оргил

Та бүхэн "Орон нутгийн сонин"-той холбоотой санал хүсэлтээ Улаанбаатар хот болон Ханбогд сум дахь Орон нутгийн харилцааны ажилтнаар дамжуулан бидэнд илгээгээрэй.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Мөнхис Цамхаг, 1 давхар, Утас: 976-11-331880, Факс: 976-11-331885

Өмнөговь аймаг, Даланзадгад сум, Цагаан булагийн 8-р баг. "Оюу толгой" ХХК-ийн Өмнөговь дахь Төлөөлөгчийн газар Утас: 976-7053-3961, 976-7053-3963 Факс: 976-11-331890

Өмнөговь аймаг, Ханбогд сум, Иргэдийн хөгжлийн төв. "Оюу толгой" ХХК-ийн Нийгмийн харилцааны хэлтсийн салбар Утас: 976-331880 (5316) 976-331880 (7647)

Дэлгэрэнгүй мэдээллийг ot.mn цахим хуудаснаас авна уу.